



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 460

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, нийт 24,839,000.00 /хорин дөрвөн сая найман зуун гучин есөн мянган/ төгрөгийн балансын үнэ, 24,689,918.00 /хорин дөрвөн сая зургаан зуун наян есөн мянга есөн зуун арван найман/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 3 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Я.Амаржаргал, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирал С.Энхболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн
460 дугаар тогтоолын хавсралт

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ-22069, 56-97 УБВ, арал № 70427336	2007/ 2007	147281	12,760,000.00	12,760,000.00	0	0	500,000.00
2	ММС-300, 94-40 УБУ, арал№ JMYNP23WYA000203	1999/ 2000	322708	4,969,400.00	4,820,318.00	149,082.00	0	500,000.00
3	Пажеро, 94-74 УБУ, арал№ JMVHV310W000159	1999/ 2000	397697	7,109,600.00	7,109,600.00	0	0	500,000.00
	Нийт дүн			24,839,000.00 /хорин дөрвөн сая найман зуун гучин есөн мянга/	24,689,918.00 /хорин дөрвөн сая зургаан зуун наян есөн мянга есөн зуун арван найман/	149,082.00 /нэг зуун дөчин есөн мянга наян хоёр/	0	1,500,000.00 /нэг сая таван зуун мянган/